



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/737

Улаанбаатар хот

Түр журам, үнэлгээний хуудас батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 36 дугаар зүйлийн 36.1, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх түр журам”-ыг нэгдүгээр, “Гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх, Коронавируст халдвар (КОВИД-19) батлагдсан үйлчлүүлэгчийн өөрийгөө хянах хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ц.Билэгтсайхан), Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эмнэлгийн тусламж үйлчилгээний газар (Б.Буянтогтох)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Түр журам, үнэлгээний хуудас батлах тухай” А/239 дугаар, “Коронавируст халдварын үеийн хариу арга хэмжээний зураглал батлах тухай” А/319 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141212390

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 11.
дүгээр сарын 30 өдрийн 4/237 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**ГЭРИЙН ТУСГААРЛАЛТАД ЭМЧЛЭГДЭХ, КОРОНАВИРУСТ ХАЛДВАР
(КОВИД-19)-ЫН БАТЛАГДСАН ТОХИОЛДОЛД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ТҮР ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын эмнэлзүйн шинж тэмдэггүй болон хүндрэх эрсдэлгүй хөнгөн хэлбэрийн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хариу арга хэмжээ авахад оролцогч талуудын үүрэг, хариуцлагатай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын эмнэлзүйн шинж тэмдэггүй болон хүндрэх эрсдэлгүй хөнгөн хэлбэрийн шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчийг гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд Халдварт өвчин судлалын үндэсний төв, аймаг, нийслэлийн хэмжээнд Эрүүл мэндийн газар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд харьяа анхан шатны эрүүл мэндийн байгууллага, шуурхай хариу арга хэмжээний баг эрэмбэлж, үнэлгээ хийн, үйлчлүүлэгчийг гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах тухай шийдвэрийг гаргана.

1.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх үйлчлүүлэгчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв хариуцаж, зохион байгуулалтыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар хариуцан хэрэгжүүлнэ.

1.5. Үйлчлүүлэгчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд эмчийн үзлэг, эмчилгээ, хяналт, тандалт, сэтгэл зүйн зөвлөгөө, түргэн тусламжийн үйлчилгээ, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хамаарна.

Хоёр. Гэрийн тусгаарлалтад эмчилж, хянах шалгуур

2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэггүй болон хүндрэх эрсдэлгүй хөнгөн хэлбэрийн батлагдсан тохиолдлыг гэрийн тусгаарлалтад эмчлэн хянана.

Гурав. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эрх, үүрэг

3.1 Гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх тохиолдлын эмчилгээ, хяналтыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч болон бусад эмнэлгийн мэргэжилтнүүд хийнэ.

3.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нь өрх, сум, тосгоны эмч болон шуурхай хариу арга хэмжээний багийн үнэлгээгээр гэрийн тусгаарлалтад эмчилж, хянах шийдвэр гаргасан тохиолдлын мэдээллийг авч, үйлчлүүлэгч болон гэр бүлийн гишүүдийн бүртгэлийг тандалтын системийн бүртгэлтэй тулгаж, хянана.

3.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчийг тандалтын системд бүртгэгдсэнээс хойш 24 цагийн дотор эрэмбэлэн, шаардлагатай тохиолдолд гэрт нь очиж үнэлэн, эмчилж зөвлөн хянана.

3.4. Гэрийн тусгаарлалтад эмчлэгдэж байгаа үйлчлүүлэгчид эмчилгээ, хяналтын явцад халдвараас сэргийлэх дэглэм, “өөрийгөө хянах хуудас” (маягт 1)-ийг хэрхэн бөглөх талаар зааварчилгаа өгч, хяналт тавина.

3.5. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь гэрийн тусгаарлалтад эмчлэгдэж байгаа үйлчлүүлэгчийг эдгэртэл биеийн байдал, илэрч буй эмнэлзүйн шинж тэмдгийг хянаж, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд лавлагаа шатлалын эмч нараас зөвлөгөө авч тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

3.6. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон шуурхай хариу арга хэмжээний баг нь шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн гэрт нь очиж үзлэг, оношилгоо хийж, эмнэлэгт хэвтүүлэх шийдвэр гаргана.

3.7. Гэрийн тусгаарлалтад байгаа үйлчлүүлэгчийн эмчилгээ, хяналт, тусламж үйлчилгээ, эмнэлэгт хэвтүүлсэн, өөр аймаг, дүүрэг, байгууллагад шилжүүлсэн, эмчийн хяналтаас гаргасан тухай мэдээ, мэдээллийг тандалтын системд тухай бүр үнэн зөв хөтөлнө.

3.8. Гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах үйл ажиллагаанд саад учруулж байгаа иргэдийг холбогдох байгууллагад мэдээлнэ.

3.9. Үйлчлүүлэгчид дараах дэмжих үйлчилгээ шаардлагатай тохиолдолд харьяа орон нутгийн онцгой комисстой хамтран ажиллана:

3.9.1. Иргэдийн хүсэлтээр хоол хүнс, ахуйн хэрэглээний бараа хүргэж өгөх,

3.9.2. Хог хаягдлыг цуглуулах, халдваргүйтгэл хийх,

3.9.3. Гэрийн тусгаарлалтын дэглэм мөрдөх,

3.9.4. Бусад нийгмийн хамгааллын үйлчилгээ.

Дөрөв. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

4.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай нь батлагдсан үйлчлүүлэгч нь эмчийн зааврын дагуу тандалтын системийн цахим асуумж (маягт 1)-ийг бөглөж, эрүүл мэндийн байгууллагад биеийн байдлын талаар үнэн, зөв мэдээлэл өгнө.

4.2. Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний өгсөн заавар, зөвлөгөөг чанд мөрдөнө.

4.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй өдөрт утсаар холбогдох эсхүл тандалтын системийн “Эрүүл мэндийн хяналт” хэсэгт байршуулсан хуудсаар үнэн, зөв мэдээллийг өгнө.

4.4. Өөрийн эрүүл мэндэд хяналт тавьж, өөрийгөө хянах хуудсанд бичсэн эмнэлзүйн шинж тэмдэг нэмж илрэх, сэтгэл зүйн тавгүй байдал үүсэх болон өөр зовуурь илэрсэн тохиолдолд хяналтын эмчид яаралтай мэдэгдэж, зөвлөгөө, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авна.

4.5. Үйлчлүүлэгчид коронавируст халдвар (КОВИД-19)-аас бусад өвчин, эмгэгтэй холбоотой төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд харьяа анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтын эмч болон аймаг, нийслэлийн шуурхай хариу арга хэмжээний баг, аймаг, нийслэлийн түргэн тусламжийн төвд хандана.

4.6. Эмчийн өгсөн зааврын дагуу эм уух ба уусан эмтэй холбоотой урвал гарсан тохиолдолд эмчид яаралтай мэдээлнэ.

4.7. Хувийн ариун цэвэр, халдвараас сэргийлэх дэглэмийг чанд сахиж, бусдад халдвар тараахаас сэргийлнэ.

4.8. Тусгаарлалтын хугацаанд гадагшаа гарахыг хориглоно.

Тав. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын эрх, үүрэг

5.1. ХӨСҮТ, ЭМХТ-тэй хамтран эмнэлгийн мэргэжилтэн болон сайн дурын ажилтанд коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн шинж тэмдгийг таних, эрэмбэлэн ангилах, эмчилгээ, хяналт, халдварын сэргийлэлт, хамгаалах хувцас хэрэгслийн зөв хэрэглээ, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэх, сэтгэл зүйн бэлэн байдлын сургалтад хамруулж бэлтгэсэн байна.

5.2. Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд мэдээлэл шуурхай солилцох цахим сүлжээг байгуулж, нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах ба тандалтын системийг ашиглах, мэдээллээр хангах зохицуулалтыг хийнэ.

5.3. Шаардлагатай тохиолдолд нэмэлтээр дайчлан ажиллуулах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, резидент эмч, оюутан, сайн дурын ажилтны судалгааг холбогдох байгууллагатай хамтран гаргаж баталгаажуулсан байна.

5.4. Гэрийн тусгаарлалтад эмчлэгдэж байгаа өвчтөнд төрөлжсөн мэргэшлийн эмчийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохиолдолд хэвтүүлэн эмчлэх эмнэлгийн хуваарийг тусламж, үйлчилгээний чиглэл, төрлөөр гаргаж, зохион байгуулна.

5.5. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тандалтын системийн ашиглалт, холбогдох судалгаа, мэдээнд өдөр бүр хяналт тавьж ажиллана.

5.6. Мэдээлэл солилцох урсгалын дагуу гэрийн тусгаарлалтад эмчилж, хянасан тохиолдлын бүртгэл, судалгаа, эмчилгээний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг гаргаж холбогдох байгууллагуудад тухай бүр хүргүүлнэ.

5.7. Орон нутгийн онцгой комисстой хамтран өвчтөнд нийгмийн хамгааллын болон бусад үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг тухай бүр авна.

Зургаа. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эрх, үүрэг

6.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэх, хянах, тандах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллана.

6.2. Тандалтын системийн холбогдох мэдээ, мэдээллийг нэгтгэн дүгнэх, нөхцөл байдлын үнэлгээ, дүгнэлт хийж, мэдээллээр хангаж ажиллана.

| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|---|--|--|--|--|
| 7 | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | |
| 9 | | | | | | | | | |
| 10 | | | | | | | | | |
| <p>Дараах шинж тэмдгийн аль нэг нэмж илэрвэл өрх, сум, тосгоны эмчид утсаар яаралтай мэдэгдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Өндөр халуурах /халуун бууруулах эм ууснаас хойш 2 цагийн дотор халуун буурахгүй байгаа/ • Амьсгал давчдах • Бүтэн өгүүлбэрээр ярьж чадахгүй амьсгаадах • Уруул, хэл, амны салст хөхрөх • Ханиалгалт нэмэгдэх • Цээжээр өвдөх • Бөөлжих • Суулгах • Тууралт гарах • Нүд үрэвсэх • Булчингаар өвдөх | | | | | <ul style="list-style-type: none"> • Үе мөч өвдөх • Хамраас цус гарах • Татах • Ухаан балартах. <p>Хэрэв пульсоксиметр байгаа бол зааврын дагуу тайван үед хэрэглэж, 1 минут дахь зүрхний цохилтын тоо, SpO2 (сатураци) буюу захын цусны хүчилтөрөгчийн ханамжийг тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Зүрхний цохилтын тоо 1 минутад >100 байх • SpO2 (сатураци) <94% байх. <p>Жич: Өвчтөнд амьсгал тоолох аргыг зааж өгсөн байх ба эсхүл эмнэлгийн мэргэжилтэн цахим үзлэг хийж, амьсгалын тоо, пульсоксиметрийн үзүүлэлтээр биеийн байдалд үнэлгээ өгнө.</p> | | | | |